



БОЛОВСРОЛ,
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



Монгол Улс: Дээд боловсролын шинэчлэл төсөл

АХБ Төслийн дугаар. 43007-023

Төслийн код: ДБШТ МОН Зээлийн дугаар. 2766

“Дээд боловсролын шинэчлэл” зөвлөх үйлчилгээ

**ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫГ
БЭХЖҮҮЛЭН ТЭДНИЙГ ТУХАЙН БҮС НУТГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР БОЛГОХ
ТАЛААР АВАХ СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨВЛӨГӨӨ**

Их сургуулийн засаглалын зөвлөх баг

Доктор Питер Саймон Хорн, Ph.D., LL.M.
Багын ахлагч

Доктор Ж.Сүхбаатар, Ph.D.
Багын дэд ахлагч



2016 оны 6 дугаар сар
Улаанбаатар хот



**ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫГ БЭХЖҮҮЛЭН ТЭДНИЙГ ТУХАЙН БҮС НУТГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР БОЛГОХ ТАЛААР АВАХ СТРАТЕГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨВЛӨГӨӨ**

Дээд боловсролын засаглалын талаар ажилласан зөвлөхүүд Петер Хорн, Ж. Сүхбаатар нарын боловсруулсан Хөдөө Орон Нутгийн Дээд Боловсролын Сургалтын Байгууллагыг Хөгжүүлэх гол үйл ажиллагааны төлөвлөгөө

Төлөвлөгөө хэрхэн боловсруулсан тухай танилцуулга

Их сургуулийн засаглалын зөвлөхүүдийн ажлын удирдамжинд тусгагдсан нэг чухал ажил бол асуудал бол зөвлөх багийн бусад гишүүдтэй хамтран ажиллаж хөдөө орон нутгийн их, дээд сургуулиудыг ирээдүйд хөгжүүлэн тэднийг оршин байгаа тухайн бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хурдасгуур болгох талаар авах стратегийн гол үйл ажиллагааны төлөвлөвлөгөөг боловсруулах явдал байлаа.

Одоогоор хөдөө орон нутагт нийтдээ 10 гаруй дээд боловсролын сургалтын байгууллага /ДБСБ/оршин тогтнож үйл ажиллагаа явуулж байгаагаас Ховд их сургууль, Дорнод их сургууль нь бие даасан төрийн өмчийн их сургуулийн статустай, бусад аймагт байрлаж байгаа дээд боловсролын байгууллагууд нь Улаанбаатар хотод байрлаж байгаа аль нэг их сургуулийн бүрэлдэхүүний болон харъяаны сургуулийн статустай байна. Эдгээр сургуулиудыг дор толгой сургуулийн хамт жагсаав.

№	Орон нутгийн ДБСБ-ын нэр	Аймаг, сум	Толгойлох ДБСБ	Явуулж буй сургалтын түвшин	Нийт оюутны тоо
1	Дорнод их сургууль	Дорнод аймаг, Чойбалсан сум	Байхгүй, бие даасан ДБСБ	Бакалавр, магистр, доктор	708
2	Ховд их сургууль	Ховд аймаг, Ховд сум	Байхгүй бие даасан ДБСБ	Бакалавр, магистр, доктор	2882
3	Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн	Дархан-Уул аймаг, Дархан хот	ХАИИС	Эрдэм шинжилгээ, бакалавр, магистр	1056

4	Говь-Алтай аймаг дахь анагаах ухааны сургууль	Говь-Алтай аймаг	АШУҮИС	Бакалавр	574
5	Дархан-Уул аймаг дахь анагаах дээд сургууль	Дархан-Уул аймаг, Дархан хот	АШУҮИС	Бакалавр	653
6	Дорноговь аймаг дахь анагаах дээд сургууль	Дорноговь аймаг	АШУҮИС	Бакалавр	652
7	Архангай аймаг дахь багшийн сургууль	Архангай аймаг	МУБИС	Бакалавр, магистр	1052
8	Завхан сургууль	Завхан аймаг	МУИС	Бакалавр, магистр	424
9	Орхон их сургууль	Орхон аймаг, Эрдэнэт хот	МУИС	Бакалавр, магистр	911
10	Завхан аймаг дахь хөгжим бүжгийн коллеж	Завхан аймаг	СУИС	Бакалавр	62
11	Ховд их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль	Баян-Өлгий аймаг	Ховд ИС	Бакалавр	539
12	Дарханы Технологийн дээд сургууль	Дархан-Уул аймаг, Дархан хот	ШУТИС	Бакалавр, магистр, доктор	1258
13	Отгонбилэгийн нэрэмжит Технологийн дээд сургууль	Орхон аймаг, Эрдэнэт хот	ШУТИС	Бакалавр	802
14	Өвөрхангай Технологийн дээд сургууль	Өвөрхангай аймаг,	ШУТИС	Бакалавр	42
15	Далай ван коллеж	Хөвсгөл аймаг, Мөрөн сум	ХУИС	Бакалавр, магистр	331
16	Дархан дээд сургууль	Дархан-Уул аймаг, Дархан хот	Байхгүй бие даасан ДБСБ	Бакалавр, магистр	566
17	Маргад дээд сургууль	Орхон аймаг, Баян-Өндөр сум	Байхгүй бие даасан ДБСБ	Бакалавр	548
18	Худалдааны үндэсний дээд сургууль	Баянхонгор аймаг	Байхгүй бие даасан ДБСБ	Бакалавр, магистр	225

19	Гурван тамир коллеж	Архангай аймаг, Эрдэнэбулган сум	Байхгүй бие даасан ДБСБ	Бакалавр	155
20	Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар	Дархан-Уул аймаг, Дархан хот	ХУИС	Бакалавр, магистр	330
21	Мандах бүртгэл дээд сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар	Дархан-Уул аймаг, Дархан хот	Мандах бүртгэл дээд сургууль	Бакалавр	273
22	Этүгэн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар	Дархан-Уул аймаг, Дархан хот	Этүгэн их сургууль	Магистр эчнээ	26
23	Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургуулийн Увс аймаг дахь салбар	Увс аймаг	Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургуулийн	Бакалавр	217
24	Дорнод Казакстаны их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар	Баян-Өлгий аймаг	Дорнод Казакстаны их сургууль	Бакалавр-эхний 2 жил сураад толгой сургуульд шилжсэн-147	19

Төлөвлөгөө боловсруулахад хэрэгтэй материал цуглуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Үүнд:

1. 2015 оны 11 сард ДБШТ –ын зөвлөх үйлчилгээний багийн дээд боловсролын засаглал болон дээд боловсролын санхүүжилт хариуцсан үндэсний зөвлөхүүд Дорнод аймаг дахь Дорнод их сургуульд томилолтоор ажиллаж тухайн сургуулийн ажил байдалтай танилцав. Энэ явцдаа тухайн сургуулийн нийт багш нарт төслийн талаар болон дээд боловсролын шинэчлэлийн талаар мэдээлэл хийж лекц уншиж, сургуулийн удирдлагад зөвлөлгөө өгөв.
2. ДБШТ-ын Зөвлөх үйлчилгээний хүрээнд зохион байгуулагдсан бүх сургалт, семинар, хурлуудад хөдөө орон нутгийн их дээд сургуулиудын төлөөллийг оролцуулж санал бодлыг сонсож, чадавхийг нь бэхжүүлэх арга хэмжээ авсан.
3. 2015 оны 1 сарын 21, 22-нд зохион байгуулагдсан ДБ, засаглал, стратегийн төлөвлөлтийн сургалтанд орон нутгийн бүх их дээд сургуулийн төлөөллийг урьж оролцуулан орон нутгийн их, дээд сургуулийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар Ховд их сургууль, Дорнод их сургуулийн ректорууд, Эрдэнэтийн Технологийн Дээд Сургуулийн дэд захирлын илтгэлүүдийг сонслоо.

4. 2015 оны 4 сарын 30-аас 5 сарын 2-ны хооронд дээд боловсролын засаглалын үндэсний зөвлөх БСШУЯ-ны зарим ажилтнуудын хамт Орхон аймаг, Дархан-Уул аймагт ажиллаж МУИС-ийн харъяа Орхон их сургууль, ШУТИС-ийн харъяа Эрдэнэтийн Технологийн Дээд сургууль, ШУТИС-ийн бүрэлдэхүүний Дарханы Технологийн Дээд Сургуулийн удирдлагуудтай уулзаж тэдний санал зөвлөлгөөг сонсов. Энэ явцдаа Эрдэнэтийн Технологийн Дээд Сургуулийн профессор, багш нарт төслийн талаар болон дээд боловсролын шинэчлэлийн талаар мэдээлэл хийж лекц уншив.

Эдгээр ажлын үр дүнд зөвлөхүүд уг төлөвлөгөөг боловсруулах хангалттай хэмжээний мэдээлэлтэй болж чадсаны дээр уг төлөвлөгөөг боловсруулахдаа баримтлах зарчмуудаа тодорхойлсон болно. Үүнд:

- Төлөвлөгөөнд тусгах үйл ажиллагааг гурван түвшинд хуваах Засгийн газар/БСШУЯ, орон нутгийн засаг даргын тамгын газар /ЗДТГ/ болон орон нутгийн ДБСБ гэж.
- Төлөвлөгөөнд хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааг багцалж томоохон, хөтөлбөрийн шинжтэй, чухал ач холбогдолтой арга хэмжээнүүдийг тусгах, тэдгээргийг цаашид тухайн орон нутгийн түвшинд задалж нарийвчлах боломжтой байх.
- Сургуулийн өөрийн хүчээр хийж болох, эсвэл ер нь хийгдээд явж байгаа өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөгөөнд оруулахгүй байх
- Төлөвлөж буй үйл ажиллагааг ирэх 5-7 жилийн дотор хэрэгжүүлэхээр тооцох зэрэг болно.

Хэлэлцүүлсэн байдал

Төлөвлөөний эхний хувилбарыг боловсруулан 2016 оны 5-р сарын 26-нд Дорноговь аймагт болсон орон нутгийн их дээд сургуулиудад зориулсан сургалт, эрдэмшинжилгээний хурлын үеэр нийт оролцогчдод танилцуулан хэлэлцүүлж, санал бодлыг нь авлаа. Нийт оролцогчид энэхүү төлөвлөгөөг маш их дэмжиж зөв зүйтэй олон асуудал тусгагдсан байгааг тэмдэглэж байлаа. Энэ хурлын үеэр гарсан санал зөвлөжүүдийг тусган сайжруулсан хувилбарыг энэхүү тайланд оруулсан болно.

Батлах, хэрэгжүүлэх талаарх санал зөвлөмж

Эхний шатанд БСШУЯ- нэгжийн дарга нарын хурал, Дээд боловсролын Бодлогын зөвлөлөөр хэлэлцүүлж Сайдын тушаалаар батлах.

Сайдын тушаалдаа тус төлөвлөгөөг жил бүр БСШЯ-ны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхээр зааж өгөх. Мөн тодорхой арга хэмжээг нарийвчлан боловсруулж жилийн төсөв төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтэнд хяналт тавих, хэрэгжилтийн явцыг үнэлэх үүрэг бүхий ажлын хэсгийг орон нутгийн ДБСБ-ын төлөөлөлтэйгээр уг тушаалаар байгуулах хэрэгтэй байна.

Энэ тохиолдолд төлөвлөгөөг хурдан хугацаанд баталж албажуулах боловч хэрэгжилтэнд бүх холбогдох талуудыг бүрэн хамарч оролцуулж чадахгүй байх сул талтай юм. Ялангуяа орон нутгийн ИТХ болон ЗДТГ-тай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээнүүд хугацаа хоцрох, хэрэгжихгүй байх магадлалтай.

Хоёрдох шатанд, энэ асуудлаар Засгийн газар тогтоол гаргаж хэрэгжүүлэлтийг БСШУЯ болон холбогдох бусад газрууд, аймгуудын засаг дарга нарт даалгах. Энэ тохиолдолд төлөвлөгөөг баталсан засгийн газрын тогтоол гаргахад нэлээд хугацаа алдах магадлалтай боловч хэрэгжилт нь сайн байх боломжтой.

**ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫГ БЭХЖҮҮЛЭН ТЭДНИЙГ ТУХАЙН БҮС НУТГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР БОЛГОХ ТАЛААР АВАХ СТРАТЕГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨВЛӨГӨӨ**

№	СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ	ОРОЛЦОГ Ч ТАЛУУД	ШИЙДВЭ Р ГАРГАХ ХУГАЦАА	ХЭРЭГЖҮҮЛ ЭХ ХУГАЦАА	ТАЙЛБАР
Нэг.	Монгол улсын Засгийн газар, БСШУЯ-ны түвшинд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа				
1.1	Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилттэй судалгааны ажлын 20-иос доошгүй хувийг бүс, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн судалгаанд чиглүүлж орон нутагд байгаа ДБСБ-аар	БСШУЯ, ШУТС	2017	2017 оноос	Орон нутгийн хөгжилд чиглэсэн судалгаа шинжилгээний
1.2	Гадаадад их, дээд сургуулийн багш, судлаачдыг улсын төсвийн хөрөнгөөр болон ОУ-ын төсөл, хөтөлбөрийн зардлаар сургах, дадлагажуулах ажилд хамрагдах хүмүүсийн 20-иос доошгүй хувийг орон нутгийн ДБСБ-аас бүрдүүлж байх шийдвэр гаргаж мөрдүүлэх.	БСШУЯ, Төсөл хөтөлбөрүүд	2017	2017 оноос	Энэ асуудлаар журам боловсруулж Сайдын тушаал гарган хэрэгжүүлэх боломжтой

	багийн бүрэлдэхүүнд орон нутгийн ДБСБ-ын төлөөлөл заавал оруулдаг журам				
1.3	Орон нутгийн их сургуулиудад түр хугацаагаар очиж ажиллах эрдэмтэн, доктор, профессорын тэтгэлгийн санг бий болгож жил бүр 50-иас доошгүй эрдэмтдийг орон нутагт 7-оос доошгүй хоногоор ажиллуулдаг болгох	БСШУЯ-ны ДБ хэлтэс, санхүү, эдийн засгийн	2016	2017-2018 оны хичээлийн жилээс	БСШУЯ-ны төвлөрсөн арга хэмжээний төсөвт жил бүр 25-50 сая төгрөг зөвхөн энэ ажилд зориулан
1.4	Эрдэнэтийн Технологийн дээд сургууль, Орхон их сургууль, Дарханы ТДС, ХААДС зэргийг нэгтгэн Монгол улсын Хангайн бүсийн Их Сургууль байгуулж, кампус хэлбэрээ хөгжүүлэх	Засгийн газар, БСШУЯ	2018	2018-2019 оны хичээлийн жилээс	ЗГ-ийн мөрийн хөтөлбөрт ТДС-ийг түшиглэн Геологи, уул уурхайн их сургуулийн хотхон байгуулах заалт бий. Баруун бүс, зүүн бүсэд их сургуулиуд бий. Хангайн, хойд аж үйлдвэрийн бүсэд их сургууль
1.5	Дээрх их сургууль болон Эрдэнэтийн УБҮ, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, цементийн үйлдвэр зэрэг томоохон үйлдвэрүүдийн оролцоотой Шинжлэх ухаан технологийн корпораци байгуулж	Засгийн газар, БСШУЯ болон бусад	2017	2017 оноос бүрэн ажиллаж эхлэх	ШУТ-ын корпораци нь ШУТ паркийг бодвол илүү идэвхтэй үйл
1.6	Дээр дурьдсан ШУТ-ийн корпорацийг Дарханы ТДС-ийн шинэ өргөтгөлд байрлуулахын зэрэгцээ уг корпорацийн суурь болсон сургууль дундын судалгааны лабораторуудыг олон талт хамтын	Засгийн газар, БСШУЯ	2017	2017-2020	Улсын төсөвийн хөрөнгө оруулалт юм уу гадаадын зээл, тусламжийн хүрээнд
1.7	Зүүн бүс, баруун бүсэд судалгаа шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чадавхи бэхжүүлэх тусгайлсан арга хэмжээ авах	Засгийн газар, БСШУЯ	2018	2018-2022	Газар дээр нь судалгаа хийж улсын төсөвийн хөрөнгө оруулалт юм уу гадаадын

					шийдвэрлэх шаардлагатай
1.8	Орон нутгийн ДБСБ-аас Улаанбаатар хотын их, дээд сургуулиудад докторантурт суралцаж буй багш нарыг дэмжих, санхүүгийн туслалцаа үзүүлэх	БСШУЯ, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл	2016 оноос	2016- 2018	
Хоёр. Орон нутгийн ИТХ, ЗДТГ-ын түвшинд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа					
2.1	Бүс нутаг, аймаг, орон нутгийн хөгжлийн гол хүчин зүйлийн судалгаа, тогтвортой хөгжлийн 2025, 2030 он хүртэлх хөтөлбөр, зорилго, зорилтуудыг шинээр болон шинэчлэн	Аймгуудын ИТХ, ЗДТГ	2016- 2018	2016- 2018	
2.2	Дээрх ажлын хүрээнд бүс нутгийн хөгжилд орон нутгийн ДБСБ-ын гүйцэтгэх үүрэг ролийг тодорхой болгох	Аймгуудын ИТХ, ЗДТГ, Их, дээд, мэргэжлийн сургуулиуд	2016- 2018	2016- 2018	
2.3	Бүс нутаг, аймгийн Хүний хөгжлийн бодлогын зөвлөлийг Иргэдийн Төлөөлөгчдын Хурал /ИТХ/, ЗДТГ-ын дэргэд байгуулж орон нутгийн их, дээд, мэргэжлийн сургуулийн	Аймгуудын ИТХ, ЗДТГ, Их, дээд, мэргэжлийн сургуулиуд	2017- 2018	2017- 2018	Зөвлөл нь ЗД-д Хүний хөгжлийн асуудлаар зөвлөмж гаргаж өгнө
2.4	Бүс нутаг, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлуудаар /ажилгүйдэл, амьжиргааны түвшин, ядуурал, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт, жижиг, дунд бизнесийг дэмжих, цалин хөлс, инфляци, үнийн	Аймгуудын ИТХ, ЗДТГ, Их, дээд, мэргэжлийн сургуулиуд	2017- 2018	2018 оноос хойш	
2.5	Орон нутгийн оюутны тэтгэлэг, хөнгөлөлттэй зээлийн системийг боловсруулж хөгжүүлэн ажил хэрэг Болгох	Аймгуудын ИТХ, ЗДТГ	2017- 2021	2018 оноос хойш	Орон нутгийн их дээд сургуульд суралцаж буй оюутнуудад санхүүгийн шаардлагата туслалцаа үзүүлэх хэрэгтэй байна.

2.6	Орон нутагт байгаа ДБСБ-ыг удирдах ажилтнуудыг ИТХ болон ЗДТГ-ын бодлого, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг, хороодын бүрэлдэхүүнд оролцуулж	Аймгуудын ИТХ, ЗДТГ	2017-2021	2017 оноос	
2.7	Орон нутгийн ДБСБ-ыг санхүүжүүлэх, материаллаг баазыг нь бэхжүүлэх, дэмжин туслах талаар шаардлагатай арга хэмжээг авах	Аймгуудын ИТХ, ЗДТГ, Их, дээд, мэргэжлийн сургуулиуд	Тухай бүр	2017 оноос	
2.8	Сум, орон нутгийг хөгжүүлэх сангийн дүрэмд зохих өөрчлөлт оруулан тус сангийн тодорхой хэсгийг сургалт явуулах, судалгааг санхүүжүүлэхэд зориулах. Сургалт, судалгааг орон нутгийн ДБСБ-ыг	Орон нутгийн ИТХ, ЗДТГ, ДБСБ	2017	2018 оноос	Сум хөгжүүлэх сангийн 20-иос доошгүй хувийг сургалт, судалгаанд
Гурав. Орон нутгийн их, дээд сургуулийн түвшинд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа					
3.1	Профессор, багш, судлаачдын орон нутгийн хэрэгцээнд тохирсон судалгаа шинжилгээ хийх үр чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. Үүнд зах зээлийн судалгаа, нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогын судалгаа, ажилгүйдэл ядуурлын судалгаа хийх, стратегийн болон бизнес төлөвлөгөө боловсруулах, ЖДҮ-рт диагноз тогтоох,	Орон нутгийн ДБСБ-ууд төвийн их дээд сургуулиудтай хамтран	2017-2020	2017-2020	
3.2	Орон нутгийн их, дээд, мэргэжлийн сургуулиудын профессор, багш, судлаачдын хамтын ажиллагааг хөгжүүлэх, түршлага солилцох, хамтарч ажиллах боломжийг хангахад чиглэсэн олон талт арга хэмжээг авч хэвшүүлэх	Орон нутгийн ДБСБ-ууд	2017-2018	2017-оноос	Орон нутгийн их дээд мэргэжлийн сургуулиудын холбоог албан ёсоор байгуулж
3.3	Хөрш зэргэлдээ орны хил орчмын дээд сургуулиудтай тогтоосон харилцаагаа улам бэхжүүлэн үр дүнтэй хамтын	Орон нутгийн ДБСБ-ууд	2017-2022	байнга	

	тэднийг орон нутгийн хөгжлийн хэрэгцээний судалгаанд татан				
3.4	Бүс нутаг, орон нутгийн түвшинд төр хувийн хэвшлийн түншлэлийг /ТХХТ/ олон хэлбэрээр хөгжүүлж судалгаа шинжилгээ, үйлдвэрлэл, сургалтын уялдаа холбоо, хамтын	Орон нутгийн ДБСБ-ууд ИТХ, ЗДТГ-тай	2017-2022	байнга	
3.5	Аймаг, орон нутгийн ИТХ, ЗДТГ-тай олон талаар идэвхитэй хамтран ажиллах санаачлага гаргаж, хүний хөгжлийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд манлайлах үүрэгтэй оролцож, шаардлагатай тохиолдолд сургуулийнхаа бүтцэд орон нутгийн	Орон нутгийн ДБСБ-ууд ИТХ, ЗДТГ-тай хамтран	2017-2022	2017-2022	
3.6	Нийслэлд оршиж буй их, дээд сургуулиудтай сургалтын тэнхим, хөтөлбөрийн түвшинд хамтран ажиллаж хамтарсан хөтөлбөр нээх, зарим хичээл, үйлдвэрлэлийн дадлагын кредитийг орон нутгийн ДБСБ-д	Төвийн болон орон нутгийн их дээд сургуулиуд	2017-2022	2017-2022	
3.7	Бүс, орон нутагт ажиллаж байгаа докторын зэрэгтэй болон өндөр ур чадвартай инженер-техникийн ажилтнууд, гадаадын мэргэжилтнүүдийн сургалт-судалгааны үл ажиллагаанд татан оролцуулах, тэдний зөвлөлгөөг авах	Орон нутгийн их, дээд сургуулиуд	2017 оноос эхлэн байнга	2017 оноос эхлэн байнга	
3.8	Орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжихийн тулд бизнес инкубатор, технологи дамжуулах төв, гадаадын хөрөнгө оруулалтыг зуучлах үйлчилгээ, хил орчмын худалдаа хөнгөвчлөх, зөвлөх төв,	Орон нутгийн их, дээд, мэргэжлийн сургуулиуд	2017 оноос эхлэн байнга	2017 оноос эхлэн байнга	
3.9	Орон нутгийн нийгмийн хөгжлийг дэмжихийн тулд олон талд үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө	Орон нутгийн их, дээд,	2017 оноос эхлэн	2017 оноос эхлэн	
		мэргэжлийн сургуулиуд			
3.10	Орон нутгийн ДБСБ-аас Улаанбаатар хотын их, дээд сургуулиудад доктоантурт суралцаж буй багш нарыг дэмжих, бүтээлээ хийх чөлөө зав гаргаж өгөх талаар ажиллах	Орон нутгийн их, дээд, мэргэжлийн сургуулиуд	2017 оноос эхлэн байнга	2017 оноос эхлэн байнга	